

ТАНИЛЦУУЛГА

“Журам батлах тухай” Нийгмийн
даатгалын үндэсний зөвлөлийн
тогтоолын төсөл боловсруулсан тухай

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17¹ дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ: 1/ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт; 2/ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон сурталчилгаа”, 17.2 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээний зардлын хэмжээ, санхүүжүүлэх журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална” гэж тус тус заасан.

Энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэхээр “Журам шинэчлэн батлах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 10 дугаар тогтоолыг мөрдөж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилсан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална” гэж заасан.

Хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Журам батлах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын төсөл боловсруулав.

Нийгмийн даатгалын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын байдлаар 56 057 ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлсэн байна. Эдгээр ажил олгогчдод 1 033 384 албан журмын даатгуулагч хамрагдаж байна.

Эдгээр албан журмын даатгуулагчийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас гаргана.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 2023 оны 9 дүгээр сарын байдлаар 6219 иргэн 27.6 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар алдсны тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авч байгаа бөгөөд үүнээс хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч 3511 хүн, түүний зардал 22.6 тэрбум төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 462 хүн, түүний зардал 2.9 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр

алдсаны тэтгэмж авагч 1090 хүн, түүний зардал 1.3 тэрбум төгрөг байна. 2023 онд зардалд 58.8 тэрбум төгрөг, 2024 онд 59.3 тэрбум төгрөг төсөвлөсөн байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2022 онд 1.1 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд 2023 онд 1.6 тэрбум төгрөг, 2024 онд 4.3 тэрбум төгрөг төсөвлөсөн байна.

Энэхүү тогтоолын төсөл батлагдсанаар ажил олгогч, даатгуулагч хууль тогтоомжийг нэг мөр ойлгож мөрдөх ба тогтоолыг хэрэгжүүлэхэд улсын болон нийгмийн даатгалын сангийн төсөвт нэмэлт санхүүжилт шаардагдахгүй болно.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 35 дугаар зүйлийн 35.9.8 дахь заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороотой хамтран тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Л.Мөнхзул/-т даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба (Г.Банзрагч)-нд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам шинэчлэн батлах тухай" Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэхүү тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Х.БУЛГАНТУЯА

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс
урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг
сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа (цаашид “Урьдчилан сэргийлэх арга хэмжээ” гэх)-ны ажлыг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Урьдчилан сэргийлэх арга хэмжээг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна.

1.3.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1.3.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороотой зөвшилцөн урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө (цаашид “төлөвлөгөө” гэх), төсвийн саналыг боловсруулан хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч жил бүрийн 12 дугаар сард багтаан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулна;

1.3.2.энэ журмын 1.3.1-д заасан төлөвлөгөөнд тусгагдсан урьдчилан сэргийлэх арга хэмжээг хариуцан зохион байгуулахаар шалгарсан төрийн болон төрийн бус байгууллага (цаашид “байгууллага” гэх)-тай гэрээ байгуулан санхүүжилтийг олгож, төсвийн зарцуулалт, үр дүнд хяналт тавина.

1.4.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв нь урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган хамтран ажиллана.

1.5.Урьдчилан сэргийлэх сургалтыг мэргэжлийн сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулна. Мэргэжлийн сургалтын байгууллага нь хөдөлмөр, нийгмийн

хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хөтөлбөр” тус бүрд заасан шаардлагыг хангасан, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалт зохион байгуулах гэрчилгээ авсан байна.

1.6.Урьдчилан сэргийлэх арга хэмжээг иргэд, даатгуулагч, ажил олгогчдод хүргэх, сурталчлах ажлыг Нийгмийн даатгалын ерөнхий газар энэ журмын 1.3.2-т заасан болон хэвлэл мэдээллийн, холбогдох бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

1.7.Урьдчилан сэргийлэх судалгааны ажлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт болон эрдэм шинжилгээний мэргэжлийн байгууллага, холбоо, судлаачтай хамтран гэрээний дагуу зохион байгуулна.

Хоёр.Урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох

2.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэхүү журмын 1.3.1-д заасан төлөвлөгөөнд тусгагдсан нийт төсөвт өртгөөс хамааруулан урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагын сонгон шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулна.

2.2.Ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуульд зааснаар зохицуулна.

2.3.Энэ журмын 2.1-д заасны дагуу сонгон шалгаруулсан байгууллага нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулна.

Гурав. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх

3.1.Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөр нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн тухайн жилийн шимтгэлийн орлогын 2 хувиас багагүй байна.

3.2.Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд дараах зардлыг хамааруулна. Үүнд:

3.2.1.сургалтын зардал - сургалт явуулах багшийн цагийн хөлс, албан томилолт, унааны зардал, шуудан холбооны зардал, суралцагчийн бичгийн хэрэгсэл,

байр, хоолны зардал, сургалтын модуль боловсруулах, сургалтад ашиглах гарын авлага, бэлтгэх, хэвлүүлэх зардал;

3.2.2.сурталчилгааны зардал - үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зан үйлийг бий болгох, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор хууль тогтоомжийн эмхтгэл, сурталчилгааны гарын авлага бэлтгэх, контент, шторк нэвтрүүлэх, хурал, уулзалт зохион байгуулах, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн ажлын байрны тоог бууруулсан, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн, үйлдвэрлэлийн ослын тохиолдол гаргаагүй ажил олгогчийн сайн туршлагыг урамшуулах, олон нийтэд сурталчлах, түгээх зардал;

3.2.3.судалгааны зардал –үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тандалт судалгаа, эрсдлийн болон хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, програм хангамжийн зардал, судалгааны үр дүнг хэвлүүлэх, түгээх зардал.

3.3.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь батлагдсан төсөвт багтаан урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлнэ.

3.4.Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын санхүүжилтийг сургалт, сурталчилгаа, судалгааны ажлын үр дүнг харгалзан дараах баримт бичгийг үндэслэн олгоно. Үүнд:

3.4.1.урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах хүсэлт бүхий албан бичиг, сурталчилгааны ажил гүйцэтгэх гэрээ, сургалтын хөтөлбөр, арга хэмжээний удирдамж;

3.4.2.энэ журмын 1.5-д заасан шаардлагыг хангасан гэрчилгээ;

3.4.3.урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын төсвийн тооцоо, үндэслэл, төлбөрийн нэхэмжлэх;

3.4.4.өмнө зохион байгуулсан урьдчилан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэлийн тайлан, гэрээ дүгнэсэн акт;

3.4.5.нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас өмнө оны урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг үнэлсэн үнэлгээ.

3.5.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэхүү журмын 2.3-т заасан гэрээ байгуулсан байгууллагын харьяа аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газарт батлагдсан жагсаалтын дагуу урьдчилан сэргийлэх арга хэмжээний хуваарийг баталж, санхүүжилтийг олгож, хэрэгжилтэд хяналт тавина.

3.6.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах төрийн байгууллагаас бусад байгууллагад санхүүжилтийн 40 хүртэл хувийг урьдчилан олгож болно. Үлдэгдэл санхүүжилтийг урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн зарцуулалтын тайлан, анхан шатны баримт бичиг, арга хэмжээний үр дүнгийн тайланд үндэслэн гүйцэтгэлээр санхүүжүүлнэ. Төрийн байгууллагад санхүүжилтийг 100 хувь олгож болно.

Дөрөв. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний
төсвийн зарцуулалтыг тайлагнах, хяналт тавих

4.1.Урьдчилан сэргийлэх арга хэмжээг гүйцэтгэсэн байгууллага нь төсвийн зарцуулалтын болон үр дүнгийн тайланг тухайн арга хэмжээг зохион байгуулж дууссанаас хойш ажлын 7 өдрийн дотор нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

4.2.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүн, төсвийн гүйцэтгэлийн тайланг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд хагас жил тутамд тайлагнаж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороонд хүргүүлнэ.

4.3.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо болон холбогдох хуулиар эрх олгогдсон байгууллага, албан тушаалтан урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилтийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүнд тавих хяналтыг хэрэгжүүлнэ.

Тав. Хариуцлага

5.1.Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг энэ журмын 3.2-т зааснаас өөр бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

5.2.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүн, зардлын зарцуулалтын тайланг хугацаанд нь ирүүлээгүй байгууллагын энэ журмын 3.6-д заасан үлдэгдэл санхүүжилтийг зогсоох, мөн журмын 2.3-т заасан гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

5.3.Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг зориулалтын бусаар зарцуулсан, хуурамч баримт бичиг бүрдүүлж тайлагнасан тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.